

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/189/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2026.02.23 2026	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: Д.Оюун-Эрдэнэ Утас: 88916603 Цахим хаяг: oyun-erdenede@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ХАОСЗТ	Хүн ам, орон сууцны завсрын тооллого



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.23 № 2/25

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд 256,866.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас үндсэн үйл ажиллагааны зардалд 239,119.8 мянган төгрөг, өрхийн судалгааны зардалд 14,330.9 мянган төгрөг, нийт 253,450.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 233,770.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 19,679.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллого зохион байгуулсан.

6426050070

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 94.0 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,702,241.1	3,059,241.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	2,702,241.1	3,059,241.1
354	Хангамжийн материал	2,702,241.1	3,059,241.1
35410	Бичиг хэргийн материал	215,000.0	482,000.0
35420	Аж ахуйн материал	2,487,241.1	2,577,241.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	86,637,294.9	74,650,951.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	86,637,294.9	74,650,951.6
392	Биет хөрөнгө	86,637,294.9	74,650,951.6
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,000,000.0	80,000,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,666,666.8)	(28,666,666.8)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,906,449.3	81,401,449.3
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,998,187.8)	(61,142,516.2)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,512,836.0	8,503,736.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,117,135.8)	(5,445,050.7)
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	450,000.0	450,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.0)	(450,000.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	89,339,536.0	77,710,192.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	---	---
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	89,339,536.0	77,710,192.7
51	Засгийн газрын хувь оролцоо	89,339,536.0	77,710,192.7
512	Хуримтлагдсан үр дүн	89,339,536.0	77,710,192.7
51210	Өмнөх үеийн үр дүн	106,244,858.7	89,339,536.0
51220	Тайлант үеийн үр дүн	(16,905,322.7)	(11,629,343.3)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	89,339,536.0	77,710,192.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	514,324,449.0	474,775,506.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,485,900.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	5,485,900.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	5,485,900.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	514,324,449.0	469,289,606.0

**Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	297,685,918.0	239,119,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	297,685,918.0	239,119,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	216,638,531.0	230,169,806.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	203,443,343.5	217,731,948.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,195,187.5	12,437,858.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	531,229,771.7	486,404,849.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,229,771.7	486,404,849.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,798,548.5	465,924,083.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,750,463.8	189,793,192.8
210101	Үндсэн цалин	86,868,105.8	98,350,891.3
210102	Нэмэгдэл	70,840,223.0	61,581,948.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,665,000.0	23,559,336.0
210104	Урамшуулал	6,377,135.0	4,994,709.3
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,306,308.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,389,601.0	23,200,799.0
210201	Тэтгэврийн даатгал	15,254,991.9	15,674,120.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,783,649.9	1,881,669.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	924,297.2	1,134,142.0
210204	Ажилгүйдлийн даатгал	859,357.0	747,528.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,567,305.0	3,763,340.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,523,648.0	8,111,812.0
210401	Бичиг хэрэг	1,000,000.0	968,500.0
210402	Тээвэр, шатахуун	550,000.0	5,604,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	473,748.0	444,312.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	499,900.0	1,095,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,404,000.0	4,999,100.0
210604	Урсгал засвар	6,404,000.0	4,999,100.0
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.0	980,000.0
210702	Дотоод албан томилолт	1,000,000.0	980,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	204,581,463.0	218,784,636.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	203,059,243.0	218,042,816.1
210803	Даатгалын үйлчилгээ	672,520.0	600,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,900.0	41,820.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	784,800.0	100,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,149,372.7	20,054,543.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	96,300.0	90,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	294,300.0	2,492,300.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,758,772.7	17,472,243.3

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,431,223.2	20,480,766.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,904,931.3	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,791,931.3	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,213,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,526,291.9	20,480,766.1
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,030,861.4	800,963.0
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	16,495,430.4	19,679,803.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(16,905,322.7)	(11,629,343.3)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(16,905,322.7)	(11,629,343.3)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	515,863,960.0	469,289,606.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	515,863,960.0	469,289,606.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	297,685,918.0	239,119,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	297,685,918.0	239,119,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	216,638,531.0	230,169,806.0
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	203,443,343.5	217,731,948.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,195,187.5	12,437,858.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,539,511.0	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,539,511.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	514,460,260.0	469,289,606.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,460,260.0	469,289,606.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	419,489,525.8	448,808,839.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,750,463.8	189,793,192.8
210101	Үндсэн цалин	86,868,105.8	98,350,891.3
210102	Нэмэгдэл	70,840,223.0	61,581,948.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,665,000.0	23,559,336.0
210104	Урамшуулал	6,377,135.0	4,994,709.3
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,306,308.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,389,601.0	23,200,799.0
210201	Тэтгэврийн даатгал	15,353,074.0	15,674,120.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,759,130.0	1,881,669.0

**Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	912,037.0	1,134,142.0
210204	Ажилгүйдлийн даатгал	847,097.0	747,528.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,518,263.0	3,763,340.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,573,748.0	6,065,112.0
210401	Бичиг хэрэг	1,000,000.0	992,000.0
210402	Тээвэр, шатахуун	550,000.0	3,750,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	473,748.0	444,312.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	550,000.0	878,800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.0	4,999,100.0
210604	Урсгал засвар	7,000,000.0	4,999,100.0
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.0	980,000.0
210702	Дотоод албан томилолт	1,000,000.0	980,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	205,285,213.0	220,575,136.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	203,762,993.0	219,283,316.1
210803	Даатгалын үйлчилгээ	672,520.0	600,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,900.0	41,820.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	784,800.0	650,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	490,500.0	3,195,500.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	196,200.0	196,200.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	294,300.0	2,999,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,970,734.2	20,480,766.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,444,442.3	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,539,511.0	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,791,931.3	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,213,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,526,291.9	20,480,766.1
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,030,861.4	800,963.0
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	16,495,430.4	19,679,803.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,403,700.0	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,403,700.0	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,403,700.0	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,403,700.0	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,403,700.0	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,403,700.0)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.0	0.0	106,244,858.7	0.0	106,244,858.7
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	0.0	106,244,858.7	0.0	106,244,858.7
C07	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	(16,905,322.7)	0.0	(16,905,322.7)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0	89,339,536.0	0.0	89,339,536.0
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.0	0.0	89,339,536.0	0.0	89,339,536.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	0.0	89,339,536.0	0.0	89,339,536.0
D08	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	(11,629,343.3)	0.0	(11,629,343.3)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0	77,710,192.7	0.0	77,710,192.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	256,866,100.0	233,770,896.9	23,095,203.1	91.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	242,535,200.0	220,281,357.8	22,253,842.2	90.1
Улсын төсвөөс санхүүжих	242,535,200.0	220,281,357.8	22,253,842.2	90.1
НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,330,900.0	13,489,539.1	841,360.9	94.1
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,330,900.0	13,489,539.1	841,360.9	94.1
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	256,866,100.0	233,770,896.9	23,095,203.1	91.0
УРСГАЛ ЗАРДАЛ	256,866,100.0	233,770,896.9	23,095,203.1	91.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	254,866,100.0	233,770,896.9	21,095,203.1	91.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,636,300.0	183,549,026.8	17,087,273.2	91.5
Үндсэн цалин	98,704,700.0	98,350,891.3	353,808.7	99.6
Нэмэгдэл	57,708,400.0	56,644,090.2	1,064,309.8	98.2
Унаа хоолны хөнгөлөлт	26,406,200.0	23,559,336.0	2,846,864.0	89.2
Урамшуулал	17,817,000.0	4,994,709.3	12,822,290.7	28.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,079,600.0	23,200,799.0	1,878,801.0	92.5
Тэтгэврийн даатгал	17,054,100.0	15,674,120.0	1,379,980.09	91.9
Тэтгэмжийн даатгал	2,006,400.0	1,881,669.0	124,731.0	93.8
ҮОМШӨ-ний даатгал	1,605,100.0	1,134,142.0	470,958.0	70.7

**Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Ажилгүйдлийн даатгал	401,300.0	747,528.0	(346,228.0)	186.3
Эрүүл мэндийн даатгал	4,012,700.0	3,763,340.0	249,360.0	93.8
Хангамж, бараа материалын зардал	4,097,400.0	3,065,112.0	1,032,288.0	74.8
Бичиг хэрэг	1,000,000.0	992,000.0	8,000.0	99.2
Тээвэр, шатахуун	1,000,000.0	750,000.0	250,000.0	75.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.0	444,312.0	555,688.0	44.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,097,400.0	878,800.0	218,600.0	80.1
Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.0	4,999,100.0	900.0	100
Урсгал засвар	5,000,000.0	4,999,100.0	900.0	100
Томилолт, зочны зардал	1,000,000.0	980,000.0	20,000.0	98
Дотоод албан томилолт	1,000,000.0	980,000.0	20,000.0	98
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,856,600.0	14,781,359.1	1,075,240.9	93.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,330,900.0	13,489,539.1	841,360.9	94.1
Даатгалын үйлчилгээ	676,000.0	600,000.0	76,000.0	88.8
Тээврийн хэрэгслийн татвар	42,900.0	41,820.0	1,080.0	97.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	-	22,000.0	0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	784,800.0	650,000.0	134,800.0	82.8
Бараа үйлчилгээний бусад зардал	3,196,200.0	3,195,500.0	700.0	100
Бараа үйлчилгээний бусад зардал	196,200.0	196,200.0	-	100
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.0	2,999,300.0	700.0	100
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.0	0.0	2,000,000.0	0
Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.0	-	2,000,000.0	0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.0	-	2,000,000.0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	215,838,906.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	215,838,906.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	203,401,048.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,937,858.0
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,838,906.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,838,906.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,037,943.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,244,166.0
210102	Нэмэгдэл	4,937,858.0
210105	Гэрээт ажлын хөлс	1,306,308.0

2104	Хангамж, бараа материалын зардал	3,000,000.0
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	205,793,777.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205,793,777.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,963.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	800,963.0
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	800,963.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь албан ёсны статистикийн мэдээний бодит байдлыг сайжруулах, аймгийн эдийн засаг, нийгэм, хүн амын талаарх статистикийн тоон мэдээллээр нутгийн захиргааны байгууллага, иргэд, аж ахуй нэгжийг хангах, өрхөд суурилсан түүвэр судалгааны хамралтыг сайжруулах чиг үүрэгтэй Үндэсний статистикийн хорооны харьяа байгууллага юм.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2025 онд дараах 3 зорилтын хүрээнд нийт 41 ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Статистикийн мэдээллийн эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох
2. Хүний нөөцийн хөгжлийг хангах
3. Статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- ҮСХ-ны даргын 2025 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн “Цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” Б/01 дугаар тушаалаар хэлсийн даргын цалин, нэмэгдлийг, ҮСХ-ны Тамгын газрын даргын 2025 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар албан хаагчдын цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоож өгсөн байна.

- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг мөрдөж эхэлсэн байна.

- Үндэсний Статистикийн хорооны даргын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/87 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан байна.

- Үндэсний Статистикийн хорооны Тамгын газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Аймгуудын албан хаагчдын хоол, унааны хөнгөлөлтийн нөхөх төлбөрийг шинэчлэн тогтоох тухай” Б/228 дугаар тушаал батлагдаж мөрдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд ҮСХ-ны Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газар хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант хугацааны шилэн дансны мэдээлэлд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлын тайланг аудитад ашиглав.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны 09 сарын 26-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,629.3 мянган төгрөг буюу 13.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	2,702.2	3,059.2	357.0

Үндсэн хөрөнгө	164,869.3	170,355.2	5,485.9
Хуримтлагдсан элэгдэл	(78,232.0)	(95,704.2)	(17,472.2)
Нийт хөрөнгө	89,339.5	77,710.2	(11,629.3)
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	89,339.5	77,710.2	(11,629.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн	89,339.5	77,710.2	(11,629.3)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 0.0 төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,059.2 мянган төгрөг болж өмнөх оноос 357.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 39,962.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 39,605.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 74,651.0 мянган төгрөг болж 11,986.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд ҮСХ-ны даргын 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Үндсэн хөрөнгө бүртгэх тухай” А/82 дугаар тушаалаар 5,485.9 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж хүлээн авч бүртгэсэн, үндсэн хөрөнгөнд 17,472.2 мянган төгрөгийн элэгдэл, хорогдол тооцсонтой холбоотой байна.

Тайлант онд өглөг, авлагын үлдэгдэлгүй ажилласан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 77,710.2 мянган төгрөг болж 11,629.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус байгууллага нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн санхүүгийн программ болох Acolous программыг 2007 оноос хойш ашигласан бөгөөд санхүүгийн бүртгэл тайланд 450.0 мянган төгрөгийн өртөгтэй, 450.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, тус программыг ашиглахгүй байгаа, 2023 оноос ҮСХ-оос ашиглах эрхийг нь олгосон Dynamic санхүүгийн программыг ашиглаж эхэлсэн, санхүүгийн бүртгэлд бүртгэлгүй байна. Программ хангамжтай холбоотойгоор тайлант онд зардал гараагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 326,569.6 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 11,303.5 мянган төгрөгөөр бууруулж 315,266.1 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна.

Батлагдсан төсвийг 2025 онд 3 удаа тодотгон өөрчилж, 58,400.0 мянган төгрөгөөр бууруулан 256,866.1 мянган төгрөг болгон тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 256,866.1 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 253,450.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 233,770.9 мянган төгрөг буюу 91.0 хувьтай байна. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, статистикийн бусад тооллого, судалгаа арга хэмжээний зардлууд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө болно.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (хувь)
1	70405 Албан ёсны статистик	256,866.1	233,770.9	23,095.2	91.0
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	240,535.2	220,281.3	20,253.9	91.6
1.2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	2,000.0	0.0	2,000.0	0.0
1.3	81510 Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа	8,195.5	7,723.0	472.5	94.2
1.4	81517 Статистикийн бусад тооллого, судалгаа	6,135.4	5,766.6	368.8	94.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Бүтэц орон тооны гүйцэтгэл

Байгууллагын бүтэц орон тоог ҮСХ-ны даргын 2021 оны А/166 тоот тушаалаар нийт 6 орон тоотой байхаар баталж өгсөн байна. ҮСХ-ны даргын 2025 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн “Цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” Б/01 дугаар тушаалаар хэлтсийн даргын цалин, нэмэгдлийг, ҮСХ-ны Тамгын газрын даргын 2025 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар албан хаагчдын цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоож өгсөн ба нийт 5 орон тоотой ажиллаж эхэлсэн ба тайлант онд 1 сул орон тоо нөхөгдөж, 6 албан хаагч ажилласан байна.

Ажилтныг томилох, чөлөөлөхдөө ҮСХ-ны Тамгын газрын даргын тушаал, шийдвэрийг үндэслэдэг бөгөөд 2025 онд бүтэц орон тоог өөрчлөхтэй холбоотой ямар нэгэн шийдвэр ирээгүй тул орон тооны цомхотгол хийгдээгүй байна.

Унаа, хоолны хөнгөлөлт (2100103)-ийн зардал

ҮСХ-ны даргын 2025 оны 08 дугаар сарын 07 ны өдрийн А/87 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журам, ҮСХ-ны Тамгын газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн Б/228 дугаар тушаалаар нэг ажилтанд өдрийн 20.0 мянган төгрөгөөр хоолны хөнгөлөлт тооцож олгодог байна.

Тайлант онд хоолны хөнгөлөлтийн зардалд 26,406.2 мянган төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 23,559.3 мянган төгрөг зарцуулагдсан байна.

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал

Тайлант онд хүн ам, орон сууцны тооллого, хагас жилийн мал тооллого, хүн ам, өрхийн мэдээллийн сангийн шинэчилсэн программтай холбоотойгоор аймаг

болон сумдад 18 удаагийн сургалт, семинар зохион байгуулж үндсэн үйл ажиллагааны зардлаас 1,500.0 мянган төгрөг, ҮСХ-оос нэмэлт санхүүжилтийн данс руу хуваарилан зарцуулсан 1,522.3 мянган төгрөг, нийт 3,022.3 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс төрийн үйлчилгээний албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд 4,937.9 мянган төгрөг, Баянхонгор аймгийн ЗДНХ-өөс мал тооллогын зардал болон ХАОСЗТ-ын зардлын санхүүжилтэд 7,500.0 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас судалгааны зардлын санхүүжилт, маягт хэвлүүлэх зардалд 203,401.0 мянган төгрөг, нийт 215,838.9 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрснийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, үлдэгдэл 800.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

ҮСХ-оос "Петростар" ХХК-тай ҮСХ-ны албан хэрэгцээнд шатахуун нийлүүлэх гэрээ байгуулж ажилласны дагуу худалдан авалтыг хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 256,866.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,568.7 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 1,669.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дэлгэрэнгүй мэдээлэл буюу байгууллагын ерөнхий мэдээлэл бүрэн гүйцэт байна.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 30 гүйлгээний 461,440.5 мянган төгрөгийн орлого, зарлагын мэдээллийг 100 хувь, хугацаанд нь мэдээлсэн байна.

ҮСХ-ны Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газраас ҮСХ-ны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны эхний хагас жилийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайланд Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс мэдээлбэл зохих бүх мэдээллийг хугацаанд нь 100 хувь мэдээлж ажилласан талаар тэмдэглэсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэсэн ба аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар анхаарал татсан асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----